



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/56

Хажуу шинэ-Ус

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 74 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар, "Очир хийц" иргэний бүлэгтэй байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Цэцэрлэгийн гадаах талбайн тохижилт, Дэнжийн хүүхдийн тоглоомын хашаа болон тоглоомыг засварлах ажлыг шинээр хийж гүйцэтгэх ажил үйлчилгээнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийг хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)  
Гишүүд: У.Сүнжидмаа (Тамгын газрын нягтлан бодогч)  
Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)  
Г.Мөнхсоёл (Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч)  
Д.Дулам (Боловсролын нягтлан бодогч)

2. "Очир хийц" иргэний бүлэгтэй хүлээн авах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн нэр төрөл, хэмжих нэгж, тоо ширхэг, хүчин чадал бүрээр нь акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэн авч ажиллахыг 4 дүгээр багийн Засаг дарга (Л.Батбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Т.АРИУНАА

